




ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ

/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/

**МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН
АЛБАНЫ ЗӨВЛӨЛ
Д.БААТАРСАЙХАН**

2018 он



Хуулийн төсөл өргөн баригдав.
2017.02.10



Хуулийг хэлэлцэж байгаа байдал:
2017.12.07

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 12 гишүүн 2017.02.10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурал 2017.12.07-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ

1994.
12.30

2002.
06.28

2008.
05.06

**2017.
12.07**

- Нийгмийн баталгааг сайжруулах
- Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх
- Төрийн албан хаагчдын эрх ашгийг хамгаалах
- Иргэдэд хүрэх төрийн үйлчилгээг сайжруулах

ХУУЛЬ БАТЛАГДАН ГАРАХ ПРАКТИК ШААРДЛАГА

Төрийн албаны тухай хууль боловсронгуй болсон хэдий ч төрийн албаны үйл ажиллагаа, төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг бүрэн дүүрэн хангаж чадахгүй байдал гарсаар байна. Тухайлбал:

- ▶ Төрийн албаны хүний нөөцийн бодлого тогтворгүй, албан тушаалд тавигдах шаардлага тодорхойгүй, төрийн албан хаагчийн албан тушаал /ажлын байр/ баталгаагүй, улс төрийн нөлөөлөлд автах, бие даасан хараат бус байдлаа хангаж чадахгүй байдал үргэлжилсээр ирсэн,
- ▶ Улс төрийн албан тушаалтнаас бус төрийн албан хаагч нар өөрсдөө улс төрийн нөлөөнд автдаг,
- ▶ Мэдлэг чадварт тулгуурласан **“мерит”** буюу **“Чадахуйн зарчим”**-д суурилсан, сонгон шалгаруулалтын тогтолцоог хэвшүүлэх, мэргэшсэн, тогтвортой төрийн албыг хөгжүүлж, бэхжүүлэх түүний эрх зүйн үндсийг хуульд тусгах,
- ▶ Төрийн албан хаагчийн алдааны улмаас улсын төсөвт тооцоолоогүй эрсдэл үүсч байгаа, */үндэслэлгүйгээр ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн г.м/*
- ▶ Бүх шатны төрийн албан хаагчдыг давтан сургах, мэргэшлийн багц сургалт

Хуулийн төслийн үзэл баримтлал

Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг
“Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно”

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан
“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”

3.3.2.3.төрийн бодлогын залгамж чанарыг хангах эрх зүй, зохион байгуулалтын үндсийг бүрдүүлнэ.

3.3.2.6.төрийн албан хаагчид тавигдах ёс зүй, мэдлэг, чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, цалин, хангамжийг нэмэгдүүлж, тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.3.2.7.төрийн албан хаагчид аюулгүй байдлын мэдлэг олгож, мэргэжлийн ур чадвараа байнга дээшлүүлэх, шударгаар өрсөлдөх боломж, нөхцөлийг бүрдүүлж, сонирхлын зөрчлийг хуулиар хязгаарлана

Үзэл баримтлал:

Чадахуйн зарчим /мерит/ буюу иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулахдаа хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах зарчмыг хуулиар тодорхойлж

Мэдлэг, чадвартай иргэдэд нээлт **/КАРЬЕРЫН ШАТЛАН ДЭВШИХ ТОГТОЛЦОО/**-тэй өрсөлдөөнөөр төрийн албанд орох боломж олгохын зэрэгцээ төрийн албанд нэвтрүүлнэ.


Төрийн албан хаагчдын үйл ажиллагааны үр дүнд тавих хяналтыг сайжруулж, хариуцсан ажил, үйлчилгээ, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангалтгүй зохион байгуулсан албан хаагчид хариуцлага тооцох эрх зүйн орчныг бүрдүүлэх

Төрийн албан хаагч /улс төрийн албан хаагчаас бусад/ улс төрийн аливаа үйл ажиллагаанд оролцох явдлыг таслан зогсоож, улс төрийн нөлөөнөөс ангид, ард түмнийхээ тусын тулд, зөвхөн төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллах Үндсэн хуулийн үзэл санаа бодитоор хэрэгжих боломжтой болно

Удирдлагын академийг төрийн албан хаагчдын тасралтгүй үргэлжлэх сургалт, хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулагч, судалгаа, сургалт, эрдэм шинжилгээ, арга зүйн хүрээлэн болгон өөрчилж, чадавхийг бэхжүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ;

Төрийн албан тушаалтан хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг чангатгана. Мөн ажлын гүйцэтгэл, үр дүнгээр нь төрийн албан хаагчдыг урамшуулах, хариуцлага тооцох тогтолцоо бүрдэнэ

ҮЗЭЛ БАРИМТЛАЛ



ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ ХЭРЭГЖИЛТ

- ✓ Харьцангуй баталгаатай албан тушаал
- ✓ Улс төрийн шалтгаанаар чөлөөлөгдөхгүй
- ✓ Бүтцийн өөрчлөлтөөр халагдахгүй
- ✓ Орох босго өндөр
- ✓ Гарах хаалга харьцангуй хязгаарлагдмал
- ✓ Иргэдэд чанартай үйлчилгээ үзүүлэх
- ✓ Олон нийтийн итгэл дэмжлэгэд тулгуурлах
- ✓ Алагчлахгүй ялгаварлахгүй байх

Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн бүтэц, дагаж мөрдөх хугацаа

7 хэсэг

23 бүлэг

77
зүйл


Батлагдсан:
2017.12.07



Хэрэгжих:
2019.01.01

Төрийн албаны шинэчилсэн найруулсан хууль

Хууль

- Уламжлал хадгалсан
- Шинэчилсэн
- Нийт зүйл заалтын 50% дээш өөрчлөгдсөн
- 23 /7/ бүлэг, 77 /41/ зүйлтэй
- Бүтэц  Агуулга
- Зарчим-Хэм хэмжээ тогтоосон
- Хэм хэмжээ зөрчвөл хариуцлага тооцох

Хууль хэрэгжүүлэгч

- Шинэ хандлага
- Шинэ соёл
- Шинэ арга барил
- Шинэ ур чадвар
- Шинэ хуулийг хуучин ойлголтоор хэрэгжүүлэхгүй

ХУУЛЬ ХООРОНДЫН УЯЛДАА

Монгол
Улсын
Үндсэн
Хууль

Төрийн
албаны
тухай
хууль
/шинэчилсэн
найруулга/

Бусад
салбарын
хуулиуд

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Хуулийн үйлчлэх хүрээ:

- Улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг хуулиар тогтоох бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн холбогдох заалтыг,
- Төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зүйн байдлыг энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар,
- Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг Хөдөлмөрийн тухай хууль, энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар,
- Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн тухай болон бусад хуулиар,
- Төрийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжтэй холбогдсон харилцааг энэ хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар,
- Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгчийг томилох, чөлөөлөх асуудлыг холбогдох хуулиар

ШИНЭ ЗОХИЦУУЛАЛТУУД:

3 дугаар зүйлд Нэр томъёоны шинэ тодорхойлолтууд орсон:

3.1.3. **“чадахуйн зарчим /мерит/”** гэж иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэхдээ хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлахыг;


6.1.Төрийн албыг доор дурдсанаар ангилна:

- 6.1.1.төрийн улс төрийн алба;
- 6.1.2.төрийн захиргааны алба;
- 6.1.3.төрийн тусгай алба;
- 6.1.4.төрийн үйлчилгээний алба.

18.1.Төрийн захиргааны албан тушаалыг доор дурдсанаар ангилна:

- 18.1.1.тэргүүн түшмэл;
- 18.1.2.эрхэлсэн түшмэл;
- 18.1.3.ахлах түшмэл;
- 18.1.4.дэс түшмэл;
- 18.1.5.туслах түшмэл.

Шинэ зохицуулалт: Төрийн албан тушаалд тавигдах тусгай шаардлага-Мерит зарчим



Ажилласан жилийг тогтоосон тусгай шаардлагын **50 хувийг хангасан** төрийн албан хаагчийг **үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, ёс зүй, мэдлэг, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварыг** харгалзан хугацаанаас өмнө шатлан дэвшүүлж болно.

23.4.Төрийн захиргааны албаны **албан тушаалын тодорхойлолт**ыг энэ хуулийн 23.3-т заасан журамд нийцүүлэн боловсруулж, төрийн албаны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн тухайн албан хаагчийг томилох эрх бүхий этгээд албан тушаал тус бүрээр батална.

23.5.Тухайн **байгууллагын чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсноос бусад** тохиолдолд энэ хуулийн 23.3-т заасан тусгай шаардлага болон албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахыг хориглоно.

29 дүгээр зүйл. Албан тушаалын ажлын байрны сургалт


29.1.Иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад хамруулна.

ТӨРИЙН АЛБАНЫ ШАЛГАЛТ

33.2.Төрийн жинхэнэ албаны шалгалт доор дурдсан төрөлтэй байна:

33.2.1.**ерөнхий шалгалт**;

33.2.2.**тусгай шалгалт** /тухайн албан тушаалын/



Шинэ зохицуулалт: Төрийн жинхэнэ албаны шалгалт

Ерөнхий шалгалт

Төрийн жинхэнэ алба
хаах хүсэлтэй,
хуульд заасан
**нийтлэг
шаардлагыг
хангасан иргэд**ээс
авна

- Монгол Улсын иргэн
- Дээд боловсрол
- Авлига, албан тушаалын гэмт хэрэг
- Монгол хэлний бичгийн болон ярианы
- Сэтгэцийн өвчин эмгэггүй
- Цэргийн алба

Жилд нэгээс
доошгүй удаа авна

Нөөцөд байх
хугацаа: 3 жил

Тусгай шалгалт

Албан тушаалын
сул орон тоо гарсан
тохиолдолд хуульд
заасан журмын
дагуу албан хаагч
болон иргэдээс авна

Сул орон тоо гарсан
тухай бүрд авна

Шинэ зохицуулалт: Төрийн жинхэнэ албан тушаалд томилох журам

Удирдах албан тушаалтны сул орон тоог нөхөх

- төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас, эсхүл
- удирдах албан тушаалтны нөөцөд байгаа иргэдээс



Гүйцэтгэх болон туслах албан тушаалтны сул орон тоог нөхөх

- тухайн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас, эсхүл
- холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас,



Дээрх журмаар нөхөх боломжгүй бол төрийн албан хаагчийн нөөцөд байгаа иргэдээс



Дээрх журмаар нөхөх боломжгүй бол нээлттэй сонгон шалгаруулалт зарлах

Тусгай шалгалт

Ерөнхий шалгалт

33.5.Төрийн жинхэнэ албаны **шалгалт нь сорил, ярилцлага болон бусад** хэлбэртэй байна.

33.6.Төрийн жинхэнэ албаны шалгалт доор дурдсан агуулгатай байна:

33.6.1.удирдан зохион байгуулах чадварыг шалгах;

33.6.2.дүн шинжилгээ хийх чадварыг шалгах;

33.6.3.асуудал шийдвэрлэх чадварыг шалгах;

33.6.4.манлайлах чадварыг шалгах;

33.6.5.монгол хэлний ярианы болон бичгийн чадварыг шалгах;

33.6.6.багаар ажиллах чадварыг шалгах;

33.6.7.бусад.

33.7.Төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна

Шинэ зохицуулалт: Төрийн албаны улсын нэгдсэн тоо бүртгэл, албан тушаалын тодорхойлолт

Улсын нэгдсэн тоо бүртгэл

Албан тушаал эрхэлж байгаа албан тушаалтны мэдээлэл

Албан тушаал эрхэлж байсан албан тушаалтны мэдээлэл

Удирдах албан тушаалтны нөөцийн бүртгэл

Албан тушаалын тодорхойлолт батлах журам

1. Байгууллагын нэр "Базануур" Хувьцаат компани	2. Нэгжийн нэр Инженер механикийн хэлтэс
3. Ажлын байрны нэр Уурхайн инженер	3.1. Албан тушаалын ангилал Ахлах туслах
4. Ажлын байрыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр Бүрэлдэжүүлэн сургуулийн захирал	4.1. Албан тушаалын ангилал Ахлах туслах
5. Ажлын байрны шууд харьяалан удирдах албан тушаал	5.1. Албан тушаалын нэр Уурхайн инженер
	5.2. Албан тушаал эрхлэгчдийн тоо


Б. ЧИГ ҮҮРЭГ

1. Ажлын байрны зорилго: 2. Ажлын байрны үндсэн зорилт: ✓ Уулын ажлын мэргэжлийн болон зохион байгуулалтын удирдлагаар хангах, үйл ажиллагаагаа иж компаний эрэм зорилго, зорилготой уялдуулан төлөвлөж, хэрэгжилтийг хангах ✓ Тодорхой чиглэлээр ажилчдад мэдээ олгох, компаний дотоод засаглалыг бий болгох ✓ Ашиглалтын технологийг боловсруулах, дэвшүүлэх	Уурхайн төлөвлөгөөн дагуу ажлын гүйцэтгэлд хяналт тавих зааварчилгаа өгөх, төлөвлөгөөний дагуу улсын ажлыг удирдан зохион байгуулах, дүрэм журам, техникийн нөхцлийн шаардлагыг хангах, хяналт тавих. 2.1. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт: ✓ Компаний эрэм зорилго, зорилт хэрэгжих. ✓ Төхмөлийн эрхэм шинжилгээ, судалгааны ажил мэдээ, судалгааны ажлын үр дүн болон хувицаанд гарна. Бааш нэр судалгааны ажлын арга барил бүрэн эхэмшиж, мэдээ, үр чадвар нь сайжирна. ✓ Баашилж бүрэлдэхүүнийг эрхэмжүүлж, мэдээ үр чадварыг дэвшүүлэх зорилт хэрэгжиж, мэдээт суурилсан инновацийн үр дүнтэй тогтолцоо хөгжрэнэ. ✓ Салбартаа үзэж, эхний шатны үндэслэлээр
--	---

Боловсруулах
ТАЗ-өөс
боловсруулсан
журамд нийцүүлэн
боловсруулна



Зөвшөөрөл
авах
Төрийн албаны
зөвлөл хянана



Батлах

Тухайн байгууллагын чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсноо бусад тохиолдолд өөрчлөлт оруулахыг хориглоно

Шинэ зохицуулалт: Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих



Шинэ зохицуулалт: Төрийн байгууллага, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хяналт

Стратеги төлөвлөгөө

- Төсвийн ерөнхийлөн захирагч
- хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн хугацаагаар боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах

Төрийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө

- Төсвийн шууд захирагч
- тухайн жилийн Төсвийн тухай хуульд заасан өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг зохион байгуулах зорилгоор боловсруулан баталж, хэрэгжүүлэх

Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө

- Төрийн жинхэнэ албан хаагч
- хууль тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор боловсруулж, хэрэгжүүлэх

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд олон нийтийн хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Олон нийтийн хяналтын зөвлөл ажиллахаар хуульд шинээр тусгажээ.

Шинэ зохицуулалт: Төрийн албан хаагчид шинээр олгох тусламж, нэмэгдэл хөлс

Хөдөлмөрийн тухай хуульд заасан нэмэгдэл хөлс шинээр нэмж олгоно



Төрийн захиргааны албан хаагч

Өндөр насны тэтгэвэр тогтоолгоход 36 хүртэлх сарын үндсэн цалингийн дунджаас хэтрэхгүй хэмжээгээр олгодог нэг удаагийн буцалтгүй тусламж шинээр нэмж олгоно



Төрийн үйлчилгээний албан хаагч

Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл авна

!!! Энэхүү шинээр орсон нэмэгдэл хөлс, буцалтгүй тусламжийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгоно.



Төрийн албаны төв байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн, хараат бус байдал

Төрийн албаны төв байгууллагын бүтэц

- Ажлын алба,
- Салбар зөвлөл,
- Сургалт судалгаа,
мэдээллийн нэгдсэн
сангийн нэгж

Төрийн албаны зөвлөлийн гишүүн:

- 5 гишүүнтэй /УИХТГ-1, ЕТГ-1, ЗГХЭГ-1, төрийн албан хаагчийн төлөөлөл-2/
- 45 нас хүрсэн
- төрийн удирдлага, эдийн засаг, эрх зүй, боловсролын чиглэлээр мэргэшсэн дээд боловсролтой
- ял шийтгүүлж байгаагүй
- 6 жилийн хугацаагаар томилно

Хараат бус байдал:

Зөвлөлийн үйл ажиллагаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн, нам, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглох бөгөөд зөрчсөн албан тушаалтныг төрийн албанаас халах үндэслэл болно.

Хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр

Төрийн албанд 3 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах:

35 дугаар зүйл.Хариуцлага

Төрийн жинхэнэ албан тушаалд тавих шаардлага, томилох шалгуур, сонгон шалгаруулах журам, томилох хугацаа, хориглох заалтыг зөрчсөн төрийн албан хаагчийг **төрийн албанд гурван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр хална.**

48 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах

48.1.4.төрийн албанд **гурван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах;**

76.6.Энэ хуулийн 76.4, 76.5-д заасныг зөрчсөн эрх бүхий этгээдийг төрийн албанд **гурван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр төрийн албанаас хална.**

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭХ ЖУРАМ

42.1.Хуульд өөрөөр заагаагүй бол эрх бүхий этгээд дараахь тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцсоны дагуу албан үүргийнх нь зэрэгцээ түр орлон гүйцэтгүүлж болно:

42.1.1.ээлжийн амралттай;

42.1.2.эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар чөлөөтэй;

42.1.3.дотоод, гадаад албан томилоттой;

42.1.4.зургаан сар хүртэл хугацаагаар мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан, 2 жил хүртэл хугацаагаар өндөр хөгжилтэй оронд магистр, докторын сургалтад хамрагдсан;

42.1.5.удирдах дээд байгууллага, албан тушаалтны шийдвэрээр өөр ажил үүрэг гүйцэтгэж байгаа;

42.1.6.жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй;

42.1.7.албан хаагчийг албан тушаалаас нь бууруулсан, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсантай холбоотой асуудлаар шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гараагүй;

42.1.8.албан хаагчийг албан тушаалаас нь бууруулсан, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсан;

42.1.9.албан хаагч өөр албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон;

42.1.10.албан хаагч нас барсан.

43.1.Энэ хуулийн 43.3.1-д зааснаас бусад тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тухай шийдвэрийг эрх бүхий албан тушаалтан **14 хоногийн дотор гаргана.**

43.3.Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг дараахь журмаар түр орлон гүйцэтгүүлнэ:

43.3.1.байгууллагын даргын албан үүргийг түүний дэд дарга, орлогч түр орлон гүйцэтгэх;

43.3.2.дэд дарга, орлогчгүй, эсхүл эзгүй тохиолдолд байгууллагын даргын албан үүргийг чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай зохион байгуулалтын бүтцийн нэгжийн даргаар түр орлон гүйцэтгүүлэх;

43.3.3.энэ хуулийн 43.3.1, 43.3.2-т зааснаас бусад тохиолдолд албан тушаалтны албан үүргийг тухайн төрлийн албан тушаалын чиг үүрэгт нь хамгийн ойр хамааралтай албан хаагчтай тохиролцсоны дагуу түр орлон гүйцэтгүүлэх;

43.3.4.жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй, түүнчлэн эрүүл мэндийн шалтгааны улмаас 3 сараас 1 жил хүртэл хугацаагаар эмчлүүлж, сувилуулах шаардлагатай болсон тохиолдолд албан тушаалын чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай албан хаагчаар, эсхүл төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэнийг сонгон авч, тодорхой хугацаагаар түр орлон гүйцэтгүүлэх.

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТ


Стратеги төлөвлөгөө

- ▶ Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна.
- ▶ Төсвийн шууд захирагч тухайн жилийн Төсвийн тухай хуульд заасан өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг зохион байгуулах зорилгоор **Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө** боловсруулан баталж, жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хэрэгжүүлнэ.
- ▶ **Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө**

Олон нийтийн хяналт

- ▶ Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд олон нийтийн хяналт тавих чиг үүргийг **Олон нийтийн хяналтын зөвлөл гүйцэтгэнэ.**
- ▶ Олон нийтийн хяналтын зөвлөлийг сонгон шалгаруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, зөвлөлийн ажиллах дүрмийг төрийн албаны төв байгууллага батална.

Төрийн албаны зарчмын өөрчлөлт



НЭМЭГДСЭН ЗАРЧИМ

“Төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримтлах”

- “**Чадахуйн зарчим /мерит/**”: иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэхдээ хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах /3.1.3/
- Төрийн захиргааны албан тушаалд чадахуйн зарчмыг үндсэн шалгуур болгож, түүнийг **хамгийн сайн** хангасан **хүнийг** томилно. /26.1/
- Тухайн байгууллагын чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсноос бусад тохиолдолд төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлага болон **албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахыг хориглоно.** /23.5/

Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх

Албан
тушаалын сул
орон тоог нөхөх

- Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд **шатлан дэвших** зарчмын дагуу төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас уг орон тоог нөхнө /27.1.1/

Төрийн жинхэнэ
албан хаагчийг
дэвшүүлэх,
бууруулах

- Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үндэслэн шийдвэрлэнэ /52.2/
- Ажилласан жилийн 50%-ийг хангасан төрийн албан хаагчийг **үйл ажиллагааны үр дүн**, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, ёс зүй, мэдлэг, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварыг харгалзан хугацаанаас өмнө шатлан дэвшүүлж болно. /26.3/

Хэрэгжилтийн
хяналт

- Төрийн албаны зөвлөл чадахуйн зарчмын хэрэгжилтийн талаар төрийн байгууллагын үйл ажиллагаанд **хүний нөөцийн аудит** хийнэ /66.1.4/

НЭМЭГДСЭН ЗАРЧИМ

”Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх”

Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүрэг /37/

- Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч төрийн албан тушаал эрхлэх хугацаандаа **улс төрийн** аливаа нам, эвсэл, хөдөлгөөний **үйл ажиллагаанд** ямар нэг хэлбэрээр оролцохгүй байх; /37.1.4/
- Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахих, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр төр, засгийн бодлоготой холбогдсон асуудлаар **зөвхөн албан ёсны байр суурийг** илэрхийлэх; /37.1.10/

Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл /39

- Улс төрийн намын гишүүн байх, улс төрийн нам, хөдөлгөөн, улс төрийн намын дэргэдэх төрийн бус байгууллага болон **шашны байгууллагын үйл ажиллагаанд** хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд аливаа хэлбэрээр оролцох; /39.1.5/
- Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр болон **цахим хуудас, нийгмийн сүлжээний** хэрэгслээр төрийн бодлоготой холбоотой асуудлаар **албан бус байр суурь**, улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх, улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар эерэг, сөрөг мэдээ, мэдээлэл түгээх; /39.1.13/

НЭМЭГДСЭН ЗАРЧИМ

“Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх”

Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл /39/

- Албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, бусдыг бэлгийн болон хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн аливаа хэлбэрээр дарамтлах, хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгах; /39.1.4/
- Албан тушаалын бүрэн эрхээ шашны, эсхүл шашингүй үзлийн ухуулга, сурталчилгаа хийхэд ашиглах; /39.1.8/
- Сонгуулийн сурталчилгаанд аливаа хэлбэрээр оролцох, түүнд зориулалтын бус төсвийн хөрөнгө зарцуулах, төрийн өмч хөрөнгө, албаны унаа ашиглах; /39.1.6/
- Албаны бус зорилгод байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр, мэдээллийн хангамж болон албаны мэдээллийг ашиглан завших; /39.1.11/

Зарчим = Хэм хэмжээ

Хасагдсан зарчим

1. хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас төрийн албан хаагчийн учруулсан **хохирлыг төр хариуцах.**

Төрийн албаны шинэ хуулийн зохицуулалт

- 50.1.Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай **албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ.**
- 50.2.Төрийн албаны төв байгууллага хяналт тавина.

Шинэ зохицуулалтууд

- Нийтлэг шаардлага
 - Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байгаагүй байх
 - Сэтгэцийн өвчин эмгэггүй байх
- Улс төрийн нөлөөнд автахгүй төвийг сахих, хараат бус
- Албан тушаалын тодорхойлолт зөвшөөрлөөр батална. Өөрчлөхийг хориглоно.
- Үр дүн, ёс зүй, мэдлэг, мэргэшил, туршлага, чадвар + 50
- Тухайн албан тушаалын – Тусгай шалгалт
- Тухайн албан тушаалын – Онцлог сургалт

- **Хараат бус байдал**

- Зөвлөлийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно. Зөрчсөн бол огцруулах, чөлөөлөх.

- **Үүрэг**

- Хуульд нийцсэн шийдвэр биелүүлэх
- Мэдээллийг зөвшөөрөлгүй тараахгүй байх
- Зөвхөн албан ёсны байр суурь илэрхийлэх
- Сөрөг үр дагаврыг урьдчилан анхааруулах

- **Хориглох**

- Цахим хуудсанд албан бус байр суурь, мэдээ, мэдээлэл түгээх
- Албан тушаал, тамга, тэмдэг, баримт бичиг хүлээлгэн өгөхөөс татгалзах
- Албан бус зорилгод байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүү, мэдээлэл ашиглах

Шинэлэг зохицуулалт



Төрийн албан
тушаалд
шатлан
дэвшүүлэх



Төрийн
үйлчилгээний
албан хаагчийн
ёс зүй





Төрийн албаны
зөвлөлийн
бүрэлдэхүүн



Олон нийтийн
хяналт



ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ ДАХЬ ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТЫН ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТ



- **Хариуцлага: Албан тушаал бууруулах**
 - Чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн
 - Тухайн албан тушаал эрхлэх шаардлага хангахгүй болсон
 - Хууль заасан бусад үндэслэлээр
- **Сахилгын шийтгэл**
 - Сануулах
 - Цалин хасах
 - Төрийн албанаас халах
 - Хугацаатай халах /3 жил эргэн орохгүйгээр/

Шалгалт авах журам зөрчсөн бол бүрэлдэхүүнд дахин оруулахгүй.

**Сургалт, хөгжил,
шинэлэг байдал**

ахлах түшмэл: төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх, мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх.

Албан тушаал дэвших бүрт мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байна

Мэргэшүүлэх багц сургалтын агуулга хөтөлбөрийг тухайн албан тушаалын онцлог, хариуцсан ажил, гүйцэтгэх чиг үүргийг харгалзан төрийн албаны төв байгууллага, Засгийн газар хамтран батална.

Мэргэшүүлэх багц сургалтыг Засгийн газрын харъяа төрийн албаны сургалтын байгууллага хариуцан зохион байгуулна.

Албан тушаалын ажлын байрны сургалт.

Иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад хамруулна.

Сургалтыг Засгийн газрын харъяа төрийн албаны сургалтын байгууллага хариуцан зохион байгуулна.

Сургалтын агуулга, хөтөлбөрийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тодорхойлно.

**мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор сургалтад
хамрагдах /ТЖАХ-ийн нийтлэг эрх/**

**зургаан сар хүртэл хугацаагаар мэргэшил дээшлүүлэх
сургалтад хамрагдсан, 2 жил хүртэл хугацаагаар өндөр
хөгжилтэй оронд магистр, докторын сургалтад хамрагдсан
/түр орлон гүйцэтгэх үед/**

**зургаан сараас дээш хугацааны сургалтаар (шинэ дадлага,
туршлага эзэмших сургалтыг оролцуулан) бэлтгэгдэх болсон
/төрийн жинхэнэ албан тушаалаас түр чөлөөлнө/**

**Төрийн жинхэнэ албан хаагчийг ...зохих шатны сургалтад
хамруулах /Ажлын гүйцэтгэл үр дүнгээр/**

Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

төрийн хөрөнгөөр 6 хүртэлх сарын хугацаагаар давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх сургалтад хамрагдах, энэ хугацаанд эрхэлж байгаа **албан тушаалын цалинг авах**
/ТАХ-ийн нийтлэг баталгаа/

төрийн албан хаагчийг давтан сургах, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг төрийн албаны төв байгууллагатай хамтран боловсруулж хэрэгжүүлэх
/Засгийн газрын хүлээх үүрэг/

Зөвлөлийн дэргэд сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн нэгж байна.

/Зөвлөл богино сургалт хийнэ, сургалтуудад хяналт тавина/

Гарах үр дүн

Төрийн албаны залгамж чанар, төрийн удирдлагыг бэхжүүлэх

Төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байдлыг хангах

ТАЗ

Орон тооны 5 гишүүн
(Ажлын алба болон салбар зөвлөл)

“Чадахуйн зарчим /мерит/

ТА-ны шалгалт

Шатлан дэвшүүлэх

Мэргэшүүлэх багц сургалт

Эрх зүйн байдал, нийгмийн баталгаа

Хариуцлага

Core production and development process

Сонгон шалгаруулалт тасралтгүй, ил тод, нээлттэй явагдаана



манлайлагч менежер бүхий цомхон, чадварлаг төрийн алба, албан хаагчийг төлөвшүүлэх

“чадахуйн зарчим /мерит/-д” суурилсан онгон шалгаруулалтын тогтолцоо, томилгоог хэвшүүлэх цомхон, чадварлаг, иргэндээ нээлттэй, оролцоотой, хяналттай, залгамж чанартай төрийн албыг бий болгох

ил тод

олон нийтийн хяналтын зөвлөл,

хяналттай

ТА-ны үйл ажиллагаа тасралтгүй үргэлжлэн сайжирна

ТАЗ-ийн үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдал хангагдаж хууль зүйн дагуу ажиллах нөхцлийг бий болго

Хуулийн ач холбогдол:

- улс төрөөс хараат бус, ил тод, хариуцлагатай төрийн албаны эрх зүйн үндэс бүрдэх;
- төрийн албан хаагч тогтвортой ажиллах, төрийн алба хаах шалгуур зөвхөн мэргэшлийн болон уг албыг гүйцэтгэх мэдлэг, чадвар, мэргэжлийн ёс зүйгээр тодорхойлогддог болох нөхцөл баталгаажих;
- мэдлэг, чадвартай иргэд нээлттэй өрсөлдөөнөөр төрийн албанд орох боломжийн зэрэгцээ шатлах дэвших тогтолцоог төрийн албанд нэвтрүүлэх, хариуцлагын тогтолцоог сайжруулах.

Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээ

1/төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээг эрдэмтэн, судлаач, шинжээчдийн оролцоотойгоор зохион байгуулж, дүнг 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулах;

2/хуульд заасны дагуу төрийн захиргааны албан хаагчдын цалингийн зэрэглэлийг тогтоохдоо ажлын байрны шинжилгээний дүнд тулгуурлан тухайн байгууллагын үйл ажиллагааны зохих хүрээ, албан тушаалын чиг үүрэг, хүлээх хариуцлагад тохирсон байхаар зохицуулах;

3/хуульд заасны дагуу төрийн захиргааны албан хаагчдын цалин хөлсийг тогтоохдоо өмнө авч байсан цалин хөлсөөс дордуулахгүй байх арга хэмжээ авах;

4/Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 64 дүгээр зүйлийн 64.3 дахь хэсэгт заасан Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллагыг 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор байгуулах;

5/Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ хуульд заасны дагуу 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, холбогдох дүрэм, журам, шийдвэрийг боловсруулах, өөрчлөх, шинэчлэн батлах, хүчингүй болгох.


МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ЗАХИРГАА, ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭТГЭЛИЙН ЦААШДЫН ЗОРИЛТ

Алсын хараа -5
Эрхэм зорилго
Стратегийн зорилт - 9

ЭРХЭМ ЗОРИЛГО
“Иргэдэд ойр, уян хатан, идэвхитэй, санаачлагатай, цомхон, чадварлаг, үр дүнд чиглэсэн”

Стратегийн зорилт - I
Хэрэглэгчдийг дээдлэх, иргэдэд ойр байх

Стратегийн зорилт - VIII
Гадаад орчин, зах зээлийн өөрчлөлтийг сонор, соргог мэдэрч зохицуулалт хийж



Стратегийн зорилт - V
Гүйцэтгэл, үр дүнд тулгуурласан удирдлага, санхүүгийн шинэ тогтолцоог бүрдүүлэх

Стратегийн зорилт - VI
Олавтай мэдээ, баримтад түшиглэсэн электрон мэдээллийн тогтолцоо бий болгох

**АНХААРАЛ
ХАНДУУЛСАНД
ТАЛАРХЛАА**